

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
(2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

№	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		2023 онд шаардлагатай хөрөнгө		Хэрэгжилт	Үнэлгээ
				Суурь түвшин /2021 он/	Зорилтот түвшин /2023 он/	Санхүүжилтийн хэмжээ /сая.төг/	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/		
0	1	2	3	4	5	6	7	8	9
Бүлэг 1.Хүний хөгжлийн бодлого									
Зорилго 1.4.Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжиж, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.									
1.4.2	МУХТЖҮЧ-2.3.2, ЗГҮАХ-2.5.8	Хүүхдийн хөгжлийг дэмжих "Найрамдал-2" зуслангийн цогцолбор барих	Барилгын ажлын явц, хувиар	-	40	Улсын төсөв 24,000.0	Барилгын ажил эхлээгүй тул хөрөнгө зарцуулаагүй	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/26 дугаар тушаалаар Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслан байгуулах бодлого зохицуулалт, бэлтгэл ажлыг хангаж ажиллах чиг үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийг байгуулан ажилласан. Зуслангийн зураг төсөл боловсруулах ажлыг БХБЯ-наас зохион байгуулж, "Эм Эс Эл" ХХК шалгарч зураг төслийн ажлыг бүрэн гүйцэтгэсэн. Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслангийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, стратегийг боловсруулсан. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийлгэж, дүгнэлтийг гаргуулсан. Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зусланг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгоны нутаг дэвсгэрт Хөвсгөл нуурын эрэгт нийт 60 га талбайд байгуулахаар шийдвэрлэж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын	0

								яаманд 0211841 дугаартай 5 жилээр газар эзэмших гэрчилгээ олгосон. Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслангийн зураг төслийн 3D видео танилцуулгыг хийсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар “Олон улсын Хүүхдийн Найрамдал-2” төсөл арга хэмжээний Өвлийн байрны барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. Үнэлгээний хороо нээлттэй тендер шалгаруулалтыг 3 удаа зарлаж, зохион байгуулсан боловч нэг ч оролцогч тендер ирүүлээгүй шалтгаанаар барилгын ажил эхлээгүй байна.	
1.4.3	МУХТЖҮЧ-1.2.4, ЗГҮАХ-2.5.8	Ахмад настан, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих төвийг байгуулах	Ашиглалтад орох хөгжлийн төвийн тоо	-	10	Улсын төсөв 23,632.2	Улсын төсөв 21,066.8	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Булган, Орхон, Дундговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Увс аймаг, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэгт баригдаж байгаа нийт 10 төвийн барилгын ажлыг дуусгаж улсын комисст хүлээлгэж өгөхөөс 12-р сарын байдлаар 9 төвийн барилгын ажил 100 хувь, 1 барилга 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Хан-уул дүүргийн 12-р хороонд баригдаж байгаа Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн санхүүжилт 2024 онд шилжин батлагдсантай холбоотойгоор 2024 оны 4-р сард хүлээлгэн өгөхөөр гэрээний хугацаанд өөрчлөлт оруулсан. Барилгын ажлын гүйцэтгэлд 2023 онд 21066.8 сая төгрөгийн /өссөн дүнгээр/ санхүүжилт олгогдсон.	100
Зорилго.1.5.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлнэ.									

1.5.1	МУХТЖҮЧ-2.6.2, ЗГҮАХ-2.5.4	Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, эрэлт, хэрэгцээтэй уялдуулан дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх	Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэл, эрэлт, хэрэгцээний чиглэлээр хийх судалгааны тоо	-	3	Улсын төсөв	ХЭДС 943.2	<p>Улсын хэмжээнд хөдөлмөрийн зах зээл дэх өөрчлөлтийг хянах, эрэлтийг богино хугацааны хагас жилээр тодорхойлох, ажил олгогчийн шаардлагад боловсрол сургалтын байгууллагаас бэлтгэж байгаа ажиллагчдын мэргэжил ур чадвар нийцэж байгаа эсэх, ажил олгогчид төгсөгчдийн ур чадварын болон ажиллах хүчний хомсдол зэрэг хөдөлмөр эрхлэлтэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох. Мөн хөдөлмөрийн зах зээлд дэх ажиллах хүчний цалин хөлс түүний бүтцийн талаарх мэдээллийг шинэчлэх, ААНБ-ын үйл ажиллагаа, ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт, ажлын байр тэдгээрт зарцуулж буй зардал, тэдний бодит байдал, хэтийн төлөвлөгөө зэрэг асуудлыг тоон болон чанарын үзүүлэлтээр тодорхойлох хүрээнд дараах судалгаанууд хийгдэж байна.</p> <p>1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа: Улсын хэмжээний хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, богино хугацааны ажиллах хүчний эрэлтийн төлөв байдлын талаарх мэдээллийг хүргэх зорилгын хүрээнд энэхүү судалгааг жил бүр зохион байгуулж, Хөдөлмөрийн зах зээлийн 2024 оны чиг хандлага, богино хугацааны ажиллах хүчний эрэлтийн төлөв байдлыг тодорхойлох мэдээллийг хүргэх зорилгын хүрээнд дэх судалгааны мэдээлэл цуглуулалтын ажил улсын хэмжээнд хийгдэж дуусч, үр дүнгийн тайланг боловсруулаад байна. Нийт ажлын гүйцэтгэл 95.0 хувийн биелэлттэй байна. /149.8/</p> <p>2. Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт нийлүүлэлтийн таамаглал боловсруулах. Монгол Улсын хэмжээнд хөдөлмөрийн зах зээлд ойрын 5-10 жилд эдийн засгийн үйл</p>	90
-------	----------------------------	--	--	---	---	-------------	---------------	--	----

								ажиллагааны чиглэл бүрээр бий болох эрэлттэй ажил мэргэжлээр дунд болон урт хугацааны таамаглалыг олон улсын арга аргачлалын дагуу тооцоолол хийж үр дүнгээ бодлого боловсруулагч болон хэрэглэгчдийн хэрэгцээг хангах зорилгоор судалгаа зохион байгуулах төлөвлөгөө батлагдаж 2023 оны 6 дугаар сард Салбар дундын ажлын хэсгийг байгуулан, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, шалгарсан зөвлөхтэй хамтран ажиллаж, урьдчилсан үр дүнг танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд таамаглалын ажлын явц 95.0 хувийн гүйцэтгэлтэй байна. /695.2/ 3. Цалин хөлсний бүтцийн судалгаа: Улсын хэмжээн дэх цалин хөлсний бүтэц, түүний өөрчлөлтийг судлах зорилго бүхий уг судалгааны нийт ажлын явц 90.0 хувьтай явагдаж байгаа бөгөөд улсын хэмжээнд мэдээлэл цуглуулалтын ажил дуусч, үр дүнгийн тайланг боловсруулаад байна. /98.2/	
1.5.2	МУХТЖҮЧ- 2.3.4, 2.6.2, ЗГҮАХ- 2.3.12, 2.5.8, 2.5.9	Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Орлого багатай иргэдэд чиглэсэн мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	Улсын төсөв	ХЭДС 1,398.7	Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааны хүрээнд орлого багатай иргэдэд чиглэсэн сургалтын арга хэмжээнүүдийг ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай гишүүнийг түлхүү хамруулах бөгөөд хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээнд хамруулан, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг хамтран боловсруулж, суурь сургалтын ур чадварын сургалт, танхимын болон үйлдвэр дээрх мэргэжлийн сургалт, аж ахуй эрхлэлтийн сургалт, залуучуудын сургалт зөвөлгөө, эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур	90

							<p>чадварын сургалтуудыг зохион байгуулж байна.</p> <p>Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд 2023 онд 21754 хүнийг хамруулж 2.07 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 17747 хүнийг хамруулж 1.39 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.</p>	
		Залуучуудад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, хөдөлмөрт бэлтгэх, ажлын байранд дадлагажуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	Улсын төсөв	ХЭДС 762.3	<p>Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 2023 онд нийт 56942 хүнийг хамруулж 972 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 61250 иргэн хамрагдаж 762.3 сая төгрөгийг зарцуулаад байна.</p>	100
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх Хөдөлмөр эрхлэлтийн төвийн барилгын ажлын явц, хувиар	-	50	Гадаадын зээл, тусламж 17,279.5	Гадаадын зээл, тусламж 8,760.1	<p>Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Улаанбаатар хотод Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэх тендерийг ХНХЯ зохион байгуулж тендерт шалгарсан Би энд Би Констракшн ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр БА №3 тоот гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил 2023 оны 12 дугаар сарын байдлаар 78,4 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байгаа бөгөөд 8,760,1 сая төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.</p>	100

1.5.5	МУХТЖҮЧ- 3.1.5, ЗГҮАХ- 2.5.5	Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоох	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	Улсын төсөв	-	Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэх ажлын хүрээнд дундаж цалин болон хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтөд үндэслэн 2022 он суурьтай тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүрийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар тогтоолоор баталсан.	100
-------	---------------------------------------	---	----------------------------------	---	-----	-------------	---	---	-----

Бүлэг 3.Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого

Зорилго 3.1.Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн тогтолцоог хөгжүүлнэ.

3.1.2	МУХТЖҮЧ- 2.6.5, ЗГҮАХ- 2.5.4, 2.5.5, 4.2.10	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн албан хаагчдын цалин хөлсний системийг бүтээмж, ажлын үр дүнтэй уялдуулан шинэчилж, цалин хөлсийг нэмэгдүүлэх	Инфляцын түвшинтэй уялдуулан төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	-	Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дунджаар 26-60 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Энэ хүрээнд төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 590 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт, төрийн нийтлэг үйлчилгээний /ТНУ/ албан хаагчдын цалингийн доод хэмжээ 565 мян.төгрөг байгааг 750.0 мянган төгрөгт, төрийн захиргааны албан хаагчдын цалингийн доод хэмжээ 717.0 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт, төрийн тусгай албан хаагчдын цалингийн доод хэмжээ 717.0 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт хүргэсэн.	100
			Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанарыг цалин хөлс, урамшуулалт	-	100	Улсын төсөв	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын зарим төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанар үр дүнг цалин хөлс, урамшуулалтай уялдуулах, аргачлал бий болгох, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх ажлыг 2021 оноос	100	

			ай уялдуулах гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар					<p>эхлэн хэрэгжүүлж байна. 2023 онд “Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам”-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран шинэчлэн боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн А/421, А/115, А/170 дугаар тушаалаар батлуулав. Мөн холбогдох байгууллагуудаас боловсруулан санал авахаар ирүүлсэн “Төсвийн байгууллагын нягтлан бодогчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт” батлах тухай хамтарсан тушаалын төсөл, “Журам шинэчлэн батлах тухай” /Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам, ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт/ хамтарсан тушаалын төсөлд санал боловсруулан хүргүүлэв. Түүнчлэн төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг нэгдсэн хуулиар зохицуулах, цалин хөлсийг гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулах чиглэлээр боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, шинжлэх ухаан, төрийн тусгай болон төрийн захиргааны албан хаагч гэсэн 6 бүлэгт ангилал тус бүрийн төлөөллүүдийг оролцуулан фокус группын ярилцлагыг 2023 оны 5 дугаар сард зохион байгуулсан. Уг ярилцлагын үр дүн, төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой одоогийн нөхцөл байдал, цаашид төрийн албан хаагчдын цалин хөлсийг гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулах, нэмэгдлийн хэмжээг хязгаарлах зэрэг арга хэмжээний саналыг боловсруулан Ерөнхий сайд</p>
--	--	--	--	--	--	--	--	--

							<p>болон Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөлд танилцуулсан. Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөлийн зөвлөмжөөр төрийн албаны цалин хөлс, нийгмийн баталгааны нэгдсэн тогтолцоог бий болгох арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Үүний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/126 дугаар тушаалаар Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгээс төрийн албан хаагчийн цалин хөлс, мөнгөн тэтгэмж, нөхөх төлбөр, тусламж олгох харилцааг нэг хуулиар, нийтлэг байдлаар зохицуулах “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай” хуулийн төслийг шинээр боловсруулан Улсын Их Хурлын хаврын чуулганд танилцуулахаар ажиллаж байна. Уг хууль батлагдсанаар төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгаатай холбогдсон асуудлыг төрөөс бодлогын нэгдсэн зохицуулалтаар хангах боломж бүрдэхийн зэрэгцээ төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хэрэгжилтийг сайжруулахад онцгой ач холбогдолтой. Мөн Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг баталсан. Нэгдсэн систем хөгжүүлэх арга хэмжээг ТАЗ болон Засгийн газрын хэрэг эрхлэх газар хариуцна.</p>	
--	--	--	--	--	--	--	--	--